

ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧРУУЛСАН ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХЭД ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ЧИГЛҮҮЛЭХ НЬ

DIRECTING COOPERATION OF LAW ENFORCEMENT ORGANIZATIONS TO RESTITUTE FOR INCURRED LOSSES FROM THE CRIMES



Б.АЛТАНГЭРЭЛ

ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, докторант, дэд хурандаа

ALTANGEREL B.

Head of Department of execution of court decision and law for civics and administrative cases, Institute of execution of court decision, LEU, Lt.Col. PhD Candidate,

Товч утга: Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагаанд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эд хөрөнгийн бүрэн олж тогтоон, битүүмжлэх нь цаашид шийдвэр гүйцэтгэлийн журмаар гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.

Abstract: As a result of increasing incurred losses from the crimes, there is a necessity of immediate steps concerning for restitution.

Restitution caused by the crime is vital activity to fulfill sentence purpose and restore the violated rights. In order to do that It is important to develop cooperation of Law enforcement organizations.

Түлхүүр үг: Гэмт хэрэг, хохирол, хор уршиг, төлбөр төлүүлэх ажиллагаа, хууль сахиулах байгууллага, ялтан, ялтны хөдөлмөрийн хөлс.

Key words: Crime, loss, damage, restitution, law enforcement organizations.

Монгол Улсын хэмжээнд 2015 оны байдлаар төвлөрсөн хорих анги 25, үүнээс гяндан 1, онцгой дэглэмтэй 1, чанга дэглэмтэй 11, жирийн дэглэмтэй 11 хорих анги 2002-2012 оны хооронд давхардсан тоогоор 66228 ялтныг холбогдох хууль, журмын дагуу хорих ялыг албадан эдлүүлж ялтныг нийгэмшүүлэх, иргэн, нийгэмд учруулсан хохирлыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажилласан байна. Түүнчлэн, 2009-2012 оны жилийн эцсийн байдлаар 23015 хүн шүүхээр ял шийтгүүлсэнээс 17637 хүнд хорих ял оногдуулж, 8398 хүний хорих ялыг биечлэн эдлүүлсэн¹ нь нийт ял шийтгүүлэгчдийн 76,6 хувь хорих ял шийтгүүлэгчид байсан байна. 2014 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд хорих ял эдэлж буй 6994 ялтан байгаагаас 3615 буюу 51,6 хувь нь 2 буюу түүнээс дээш давтан гэмт хэрэг үйлдэгсэд байгаа нь хорих ялын үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатайг илтгэж байна.²

Аливаа гэмт хэрэг үйлдэгдэхэд түүний улмаас бусдын эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн үр дагавар ямагт буй болдог. Эрх зөрчигдөх гэдэг нь бусдын хууль бус үйлдэл (эс үйлдэхүй)-ийн улмаас хохирогчийн хуулиар хамгаалагдсан эрхэд таатай бус үр дагавар буй болж, тухайн эрхээ өөрийн сонголтын дагуу чөлөөтэй эдлэх боломж хязгаарлагдах, алдахад хүрснийг ойлгоно.

Төрөөс хамгаалагдаж буй иргэн, нийгмийн эрх, ашиг сонирхол гэмт хэргийн

¹ Монгол Улсын Дээд Шүүхийн тайлан.(УДШ-ийн архив). 2011.УБ.

² ШШГЕГ-ын Ялтны тоо бүртгэл, судалгааны тасгийн 2014 оны эхний хагас жилийн тайлан

халдлагад өртөж, зөрчигдсөн үед түүнийг нөхөн сэргээх үүргийг төр хүлээсэн. Зөрчигдсөн эрхийг сэргээхийн мөн чанар бол гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял завшуулалгүйгээр, хохирогчийн эрхийг хуулиар хамгаалсаар байгаагаа гэм буруутай этгээдэд ял шийтгэх замаар илэрхийлж байгаад оршино.

Хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээх ялын зорилготой олон хэм хэмжээ Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тусгалаа олон хэрэгжиж байдаг.

Хохирогч, иргэний нэхэмжлэгчтэй холбоотой хуулийн эдгээр зохицуулалт нь зөрчигдсөн эрхээ сэргээлгэх ялын зорилгыг хангах боломж олгоно. Өмчийн болон аж ахуйн эсрэг, албан тушаалын зарим төрлийн гэмт хэрэг үйлдэж нийгэм төр, байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд үлэмж, их, онц их хэмжээний эд материалын хохирол учруулах нь маш түгээмэл байдаг. Гэмт хэргийн улмаас учирсан эд материалын хохирлыг барагдуулахтай холбоотой олон хэм хэмжээ Эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх хуульд тусгалаа олон хэрэгжиж байдаг. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл буюу түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг болон бусад хэрэгслийг эд хөрөнгө хураах ялаас гадуур заавал хураана” гэж заасан нь гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг төлүүлэх зорилготой зохицуулалт юм.

Эрүүгийн хуулийн 55¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт, Эрүүгийн хуулийн тусгай ангид заасны дагуу хорих ял оногдуулж болох гэмт хэрэг анх удаа үйлдсэн этгээд гэмт хэргийн хохирлыг нөхөн төлсөн, гэм хорыг арилгасан бол хуулийн тусгай ангид заасан хорих ялын доод хэмжээнээс доогуур хорих ял оногдуулж болохоор хуульчилсан. Мөн Эрүүгийн хуулийн 61 дүгээр зүйлд гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн, гэм хорыг арилгасан бол ял тэнсэх нөхцөл болгон заасан.

2013 оны гэмт хэргийн тоо бүртгэлийн мэдээнд дурдсанаар гэмт хэргийн улмаас 159 тэрбум 24 сая төгрөгийн эд материалын хохирол учирсанаас 69 тэрбум 96 сая 834 мянган төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.³

Төлбөртөй 2834 ялтан 91.237.922.2 мянган төгрөгний төлбөр төлөхөөс 490 ялтан 4.425.166.8 мянган төгрөгийн төлбөр төлсөн ба 2344 ялтны 86.812.755.4 мянган төгрөгний төлбөр төлөгдөөгүй байна. “Ялтны хөдөлмөр хийсэн хөлс”-ийг ялтан нэг бүрт олгох, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, иргэн, нийгэмд учруулсан хохирол, төлбөрийг барагдуулах чиглэлээр судалгаа хийж, тодорхой ажлыг үр дүнтэй зохион байгуулан ажиллах шаардлагтай байна.⁴

Гэмт хэрэг үйлдсэний улмаас иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирол, төлбөрийг ялтны хөдөлмөрийн хөлснөөс суутгаж хохирогчид шилжүүлэх, ялтныг ажлын байраар хангах чиглэлээр алба хаагчдад яриа, танилцуулгыг газар дээр нь очиж хийн нэгдсэн ойлголт, төсөөлөл өгч цаашдын зорилго, зорилт, чиг хандлагыг хэрэгжүүлэх бодлого, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллаж байгаа нь үр нөлөөгөө өгч байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь “Эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийтгэх тогтоолын хөрөнгө гаргуулах заалт, тэдгээрийн үндсэн дээр олгосон гүйцэтгэх” баримт бичгийг үндэслэн, гэмт хэргийн улмаас хохирсон нь шүүхээр тогтоогдсон иргэн хуулийн этгээдэд хууль тогтоомжид зааснаар төлбөр гаргуулахаар хуульд

³ Монгол Улс дахь гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал. УБ., 2014. 183-184 дэх тал

⁴ П.Гантөмөр. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн барагдуулах ажиллагааны төрийн бодлогын түүхэн хөгжил. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал (сэтгүүл). УБ., 2012.№2. 49 дэх тал

заасан ажиллагааг явуулна. Эдгээр ажиллагаанд:

- Төлбөр төлөгч буюу ялтны эд хөрөнгө байгаа талаар хуульд заасан журмаар мэдээлэл олж авах; түүний мөнгөн хадгаламж болон харилцах данснаас хасалт хийх, эд хөрөнгө болон биед үзлэг, нэгжлэг хийх, эд хөрөнгийг битүүмжлэх, албадан барьцаалах, хураах, худалдан борлуулах;

- Ялтны бусдад байгаа өмч хөрөнгөөс хуульд заасан журмын дагуу төлбөр гаргуулах;

- Хуульд заасан бусад үйл ажиллагаа тус тус багтана.

Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллагад учруулсан хохирлыг барагдуулах, энэ төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд үр дүнтэй гүйцэтгэх үүднээс хорих ял эдэлж байгаа ялтны хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажлын байраар хангах, улмаар хөдөлмөрийн хөлснөөс хохирлыг аль болох түргэн шуурхай нөхөн төлөгдөх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор 2008-2012 онд “Ялтны гэм хорын хохирол барагдуулалтыг нэмэгдүүлж, төлбөр барагдуулалтанд хяналт тавин ажиллах хөтөлбөрийг”-ийг ШШГЕГ-ын даргын 2008 оны А/102 дугаар тушаалаар батлан гаргаж, хэрэгжилтийг харьяа нэгжүүд болон ял эдэлж буй ялтнуудад сурталчлах ажлыг тухайн хорих ангиуд дээр зохион байгуулан ажиллаж байна. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлснээр:

- төлбөртэй ялтныг хугацааны өмнө тэнсэн суллахгүй байх;
- ялтныг ажлын байраар хангаж, нийгэмд зөв хүн болгон төлөвшүүлэх, тэдэнд мэргэжил олгох;

- ялтны ахуй хангамж, амьдрах орчин сайжирч, тодорхой орлоготой болгох;

- ялтны төлбөрийн мөнгийг хохирогчдод олгох ажиллагааг шуурхай олгох талаар бодит үр дүнг гаргахаар тодорхой асуудлыг дэвшүүлэн ажиллаж байна.

Ялтны хөдөлмөр эрхлэлттэй холбоотой тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх талаар цогц арга хэмжээг төлөвлөн Засгийн газарт санал оруулж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, хоригдлын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийн орлогоос хохирогчийн хохирол аль болох шуурхай нөхөн төлөгдөх нөхцлийг бүрдүүлэх талаар:

1. Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд иргэний эрх, ашиг сонирхлыг хамгаалах, түүнийг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүднээс шүүх эрх мэдлийн байгууллага, төрийн байгууллагуудын тогтолцоог шинэчлэн зохион байгуулахад ач холбогдол бүхий хуулиудыг хэрэгжүүлж эхлээд багагүй хугацаа өнгөрөөд байна. Уг шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үүрэг оролцоо улам бүр өсөн нэмэгдсээр байгаа энэ цаг үед бидний хувьд ч гэсэн шийдвэрлэвэл зохих, нэн чухалд тооцогдож буй асуудлын нэг нь гэмт хэргийн болон захиргааны хууль бус шийдвэр, үйл ажиллагаанаас иргэнд учруулсан хохирлыг барагдуулах ажиллагаа байдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь “эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийтгэх тогтоол, иргэний болон захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх⁵, түүний дотор гэмт хэргийн улмаас эрх нь зөрчигдсөн иргэн буюу төлбөр авагчийн эрхийг шүүхийн шийдвэрийн дагуу нөхөн сэргээх, учирсан хохирлыг арилгах, нөгөө талаас төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах ажиллагааг хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд албадлагын журмаар төлбөр төлөгчийн онцлогт тохируулан хэрэгжүүлж байна.

⁵ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйл

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар төлбөр төлөгчийн эд хөрөнгөнд халдах, тэдний эрхийг хязгаарлах ажлыг хуулийн хүрээнд албадлагаар хэрэгжүүлдэг онцлогтой тул түүнтэй холбоотой гарсан өргөдөл, гомдол, маргааныг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэхэд цаг хугацаа, чирэгдэл багагүй гарч, улмаар шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхолыг хамгаалах, шуурхай, энэрэнгүй байх зарчим цөөнгүй тохиолдолд алдагдаж байгааг үгүйсгэх аргагүй юм.

Хохирлыг барагдуулах ажиллагаанд тухайн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэж байгаа байгууллагын бүтэц, зохион байгуулалт, эрх хэмжээ, ажлын ачаалал, алба хаагчдын хөдөлмөрийн хөлс, урамшуулал, хариуцлагыг оновчтой тодорхойлох явдал нь хохирлыг төлүүлэхэд тодорхой хэмжээгээр эерэгээр нөлөөлдөг.

Хорих ангид ял эдэлж байгаа ялтны хувьд удаан хугацаагаар хорих ялыг биечлэн эдэлдэг бөгөөд тэдгээр нь хувьд ногдох хөрөнгө, орлогогүйгээс энэ төрлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл хангалттай биелэдэггүй. Ялтнаас учруулсан хохирлыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хохирлын хэмжээ нь хадгаламж зээлийн хоршооны хэргийн хохирлыг оролцуулан тооцоход 52.8 тэрбум төгрөгөөр өсчээ. Нийт ял шийтгүүлсэн ялтнаас учруулсан хохирлын 54.9 тэрбум төгрөгийн хохирол нь бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэрэг үйлдсэний улмаас учруулсан хохирол эзэлж байна. Өөрөөр хэлбэл, нийт гэмт хэргийн улмаас учирсан хохирлын 93 хувийг залилан мэхлэх гэмт хэрэг, 7 хувийг бусад гэмт хэрэг эзэлж байна. Энэ нь залилан мэхлэх гэмт хэрэг сүүлийн үед ихээр үйлдэгдэх болсонтой шууд холбоотой.

Манай оронд зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн энэ үед эдийн засгийн болон бусад төрлийн хүнд гэмт хэрэг олноор гарч, түүний үр дагавар нь олон хүнийг хамрах боллоо.

Түүнчлэн гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд хууль сахиулах байгууллагуудын үүрэг чухал ба энэ нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон шүүн таслах ял эдлүүлэх ажиллагаа тус бүрт онцлогтойгоор барахгүй, хамтын ажиллагаа чухлаар тавигддаг.

Үүний нэг тод жишээ бол хадгаламж зээлийн хоршоодын эздийн үйлдсэн гэмт хэрэг юм. Олон иргэдийг хохироосон энэ гэмт хэргүүдийн хохирогчдын эрх ашгийг хамгаалах үүднээс Улсын Их хурлаас Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай нэг удаагийн үйлчлэлтэй хуулийг боловсруулан баталсан билээ.

Уг хуулийн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор зохих байгууллагад санал оруулснаар Монгол Улсын Засгийн газраас 2007 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 242 дугаар тогтоолоор “Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах журам”-ыг батлуулж, хэрэгжүүлж эхлээд байна.

Хадгаламж зээлийн хоршооны 8747 хохирогчдод холбогдох хохирлоос тус байгууллагад шүүхийн шийтгэх тогтоолоор 3 шатны шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн бодит хохирол болох:

Монгол Торго, Бизнес Кредит, Оюу Алт, зэрэг нийт 12 Хадгаламж зээлийн хоршоонд холбогдох 3460 хохирогчдын 32.9 тэрбум (32.895.893.9) төгрөгийн хохирол барагдуулахтай холбоотой шүүхийн гүйцэтгэх хуудсыг хүлээн авч, хуульд заасан хойшлуулшгүй ажиллагааг зохион байгуулан явуулж байна.

Өнөөдрийн байдлаар Хадгаламж зээлийн хоршооны хохирогчдод хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр хохирлын 50 хувийг олгох ажлыг зохион байгуулж байна. Энэ онд торгох, албадан ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтануудаас бусдад

учруулсан хохирол болох 60.5 сая төгрөгийн 52 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж 35 гүйцэтгэх баримт бичгийн 30.6 сая төгрөгийн хохирлыг барагдуулаад байна.

Хорихоос өөр төрлийн ял, түүний дотор торгох ялаар шийтгүүлсэн ялтнаас гаргуулах хохирлыг гүйцэтгэх ажиллагаа хүндрэлтэй байдаг бөгөөд энэ нь торгох ялыг оногдуулж буй эрх зүйн зохицуулалт төвөгтэй, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн тодорхой төрлийн гэмт хэрэгт оногдуулахаар заасан торгуулийн хэмжээ өнөөгийн нөхцөл байдалд бүрэн нийцээгүй, зарим нэг төлбөрийн чадваргүй этгээд торгох ял шийтгүүлж байгаатай холбоотой юм.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хохирогчийн эд хөрөнгийн эрх ашгийг хамгаалах ажиллагааг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид үүрэг болгоогүйгээс гэмт этгээдийн эд хөрөнгийг эрэн сурвалжлах, олж тогтоох, хамгаалалтанд авах ажиллагаа хангалттай хийгддэггүй. Зөвхөн гэмт хэрэг, түүнд холбогдогчийг илрүүлэх чиглэлрүү түлхүү анхаарснаас гэм буруутай этгээд нь шүүхийн шийдвэр гарахаас өмнөх шатанд эд хөрөнгөө нуун дарагдуулах, бусдад шилжүүлэх, худалдан борлуулах, улмаар шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх шатанд төлбөр төлөгч хувьд ногдох ямар нэгэн эд хөрөнгө, орлогогүй, төлбөрийн чадваргүй болсон байдаг.

Хуульд "...хорих ангид ял эдэлж буй ялтны төлбөрийг түүнд ногдох эд хөрөнгөөс төлүүлж, үлдэгдэл төлбөрийг ялтны хөдөлмөрийн хөлснөөс сар бүр суутгал хийж шийдвэр гүйцэтгэх албаны дансанд төвлөрүүлж байх"⁶-аар заасан. Гэвч практикт гэмт хэрэг үйлдэж бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахад ял эдлэгсдийн ихэнх хувь нь төлбөрийн чадваргүй, хөрөнгө орлогогүй, оршин суух тодорхой хаяггүй, ганц бие байдаг. Энэ нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага ялтныг ял эдлэх хугацаанд нь хөдөлмөрт татан оролцуулж, гэмт хэрэг үйлдэж бусдад учруулсан хохирлыг барагдуулах ажиллагааг тухайн хорих ангийн онцлогт нь тохируулан зохион байгуулж байгаа боловч ихэвчлэн хохирлын хэмжээ их байдгаас шалтгаалан хангалтгүй байдаг тул энэ төрлийн гүйцэтгэлийн ажиллагаанд төрийн зохицуулалт зайлшгүй шаардлагатай байгаа юм.

Шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хорих ангид ял эдэлж буй ялтнаас гэмт хэрэг үйлдсэний улмаас бусдад учруулсан хохирлоо төлөөгүй тохиолдолд ялтныг хугацааны өмнө тэнсэн суллах саналыг шүүхэд оруулахгүй байх⁷ талаарх эрх зүйн зохицуулалтыг хуульчилсан нь өмнөх хуулиудад байгаагүй дэвшилтэй зохицуулалт болсон төдийгүй ялтнаас хохирол барагдуулахад онцгой хөшүүрэг болсон юм.

Уг эрх зүйн зохицуулалттай холбоотойгоор ялтнаас бусдад учруулсан хохирлоо нөхөн төлөх явдал өмнөх онуудаас нэмэгдэж байгаа хэдий боловч хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдэж бусдын амь бие, эрүүл мэндэд хохирол учруулснаас үүссэн гэм хорын төлбөр биелэгдэхгүй удааширч, иргэд хохирсоор байгаад дүгнэлт хийж, энэ чиглэлээр онцгойлон анхаарал хандуулах зайлшгүй шаардлага бидний өмнө тулгараад байна.

Хохирогчдод нөхөн төлбөр олгох үүднээс Гэмт хэргийн улмаас хохирсон иргэнд нөхөн төлбөр олгох тухай хуулийн төсөл боловсруулагдсан бөгөөд хуулийн төсөлд төсвөөс гадна "Хохирол барагдуулах сан" байгуулах, үүнд төрийн оролцоо зайлшгүй шаардлагатай байгаа талаар оновчтой саналуудыг тусгасан нь хэрэгжих

⁶ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 66 дахь зүйлийн 66.2 дахь заалт

⁷ Мөн хуулийн 126.1.1 дэх заалт

шийдэлээ олвол ихээхэн ач холбогдолтой зүйл болно.

Гэмт хэрэг үйлдсэний улмаас бусдад учруулсан хохирлыг барагдуулах ажиллагаанд нөлөөлж буй нөлөөллийг дүгнэж үзвэл:

-Сүүлийн жилүүдэд шунахай, залилангийн шинжтэй гэмт хэргийн гаралт эрс өсч, иргэд өөрсдөө хуулийн мэдлэг, дутмагаас гэмт хэргийн хохирогч болох эрсдэлд орж байна. Энд урьдчилан сэргийлэх ажил хангалтгүй байна.

-Гэмт хэрэг үйлдэж хорих ял эдэлж байгаа ялтныг ажлын байраар бүрэн хангах боломж хомс байна.

-Хэрэг бүртгэлт мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагааны шатанд гэмт этгээдийн эд хөрөнгийг эрэн сурвалжлах, олж тогтоох, хамгаалалтанд авах ажиллагаа төдийлөн хангалттай хийгдэггүй.

-Хууль тогтоомжид хохирогчийн эрх ашгийг хамгаалах, бусдад учруулсан хохирлыг арилгах асуудлыг зарчмын хувьд тунхагласан боловч хэрэгжүүлэх механизмыг тодорхойлон хуульчлаагүй, эрүүгийн ялын бодлогод цээрлүүлэх хандлагыг түлхүү барьсан байна.

Дээрх нөхцөл байдалтай уялдан гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагаанд хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр доорх саналыг гаргаж байна. Үүнд:

1. Цагдаагийн байгууллагаас хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад хохирлын хэмжээг бүрэн тогтоож, сэжигтэн, яллагдагчийн хууль бусаар олсон байж болзошгүй эд хөрөнгийг битүүмжлэх ажиллагааг нэг мөр гүйцэтгэх

2. Шүүхийн шатанд битүүмжлэгдсэн эд хөрөнгийн нуух, үрэгдүүлэх, бусдын нэр дээр шилжүүлэх явдал гарч болзошгүйд онцгой анхаарч ажиллах

3. Хорих ял шийтгэгдсэн ялтныг ажлын байраар хангаж, хохирол төлөлтийг эрчимжүүлэх хүрээнд хорих ангиудыг Улсын их хурал, Засгийн газрын түвшинд үйлдвэржүүлэх асуудалд онцгой анхаарах зэрэг саналыг дэвшүүлж байна.